



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А78

Улаанбаатар хот

「 Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдыг
зөвлөгөөнд оролцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалт, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Соёлын сайдын Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай 2024 онд байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”- ний 4.4-д “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг алдаршуулах арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх” зорилтын хүрээнд зохион байгуулж буй Багахангай, Багануур, Налайх дүүргийн соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдын зөвлөгөөнд дүүргийн өвлөн уламжлагчдыг оролцуулсугай.

2.Зөвлөгөөнд оролцох иргэдийн нэрсийн нэгдүгээр, зарцуулагдах хөрөнгийн төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Арга хэмжээнд зарцуулагдах 1,377,420 (Нэг сая гурван зуун далан долоон мянга дөрвөн зуун хорь) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, иргэдийн оролцоог хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс (Б.Цогжавхлан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД